



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 12

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "е", 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндсэн чиглэлийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, ард иргэдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д үүрэг болгосугай.

3. Үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд идэвх, санаачлагатай ажиллахыг аймгийн бүх шатны нутгийн удирдлагын байгууллагуудад даалгаж, нийт иргэд, аж ахуй нэгжүүдэд уриалсугай.

ДАРГА



НАРАНТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1 дэх заалтыг үндэслэн, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг "Алсын хараа-2050", Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг удирдлага болгон намуудын хөтөлбөр, иргэд, олон нийтийн саналыг тусган "Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг боловсруулав.

НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Зорилго.Үндэсний эх хэл, соёл, түүх, уламжлалаа дээдлэн байгальтай зөв харилцах чадварт суурилж, эх орноо хайрлах нэгдмэл үзэл санаатай монгол хүнийг соён гэгээрүүлнэ.

1.1 Үндэсний бахархал, эв нэгдэл

Зорилт: Байгалийн унаган төрхийг хамгаалж уламжлалт ёс заншил, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэн монгол хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билэгийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

1.1.1.Гэр бүлийн харилцаанд хүүхэд, залуучуудад эх орон, тусгаар тогтнолоороо бахархах, үндэсний соёл, зан заншлаа дээдлэн хүндлэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах зөв хандлагыг төлөвшүүлэх, айл өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулна.

1.1.2.Эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн заавал уншиж судлах түүх, соёл, урлаг, ардын аман зохиол, тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, утга зохиолын бүтээлийн жагсаалт, ном, гарын авлага гаргаж, иргэд олон нийтэд ашиглах боломжийг хангана.

1.1.3.Эх орны үзэсгэлэнт байгаль, түүхэн газар орноор ард иргэд, хүүхэд багачуудыг тойрон аялуулах хөдөлгөөн өрнүүлж хэвшүүлэх, байгаль орчин, түүх, соёлын дурсгалын ач холбогдлыг ойлгуулж, хамгаалах ухамсар төлөвшлийг олгоход чиглүүлэн, түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах үйл ажиллагаанд татан оролцуулна.

1.2 Нүүдлийн соёл иргэншилт Монгол

Зорилт: Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.

1.2.1.Монголын нүүдэлчин ахуй амьдрал, зан үйл, уламжлалыг таниулах ажлыг гэр бүл, боловсрол, соёл урлагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

1.2.2.Монгол ахуй, өв соёл, зан заншлыг илтгэсэн соёлын биет өвийг сэргээн засварлах, өвлөн үлдээх ажлыг олон нийтэд таниулан түгээнэ.

1.2.3."Монгол гэр"-ийн холбоотой ардын мэдлэгийг сургууль, цэцэрлэгээр дамжуулан хүүхэд бүрт өвлүүлнэ.

1.2.4.Орон нутагт амьдардаг үндэстэн, ястны өвөрмөц ёс заншлыг судлан, түгээн дэлгэрүүлнэ.

1.2.5.Соёлын өвд суурилсан орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлж эвент, арга хэмжээг тогтмолжуулан соёлын үйлчилгээг эдийн засгийн эргэлтэнд оруулна.

1.2.6.Баримтат өвүүдийг бүртгэн, олон нийтэд таниулан сурталчилна.

1.3 Монгол хэл, бичиг

Зорилт: Үндэсний Монгол хэл, бичгээ нийтээр сурч эзэмшин, түгээн дэлгэрүүлнэ.

1.3.1.Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрдүүлж, хүүхэд багачууд, иргэдэд эзэмшүүлэн, “Үндэсний бичгээрээ уншиж, бичигцгээ “2021-2025” аяныг өрнүүлж, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”-ыг хэрэгжүүлнэ.

1.3.2.Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах бэлтгэл ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго:Иргэдийн эрүүл энх, ая тухтай амьдрах, сурах, хөдөлмөрлөх боломжид суурилан нийгмийн баталгааг бий болгоно.

2.1 Боловсрол:

Зорилт: Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.

2.1.1.Сургуулийн өмнөх боловсролд 3-5 хүртэлх насны хүүхдийг бүрэн хамруулан, гэр бүлийн гишүүний ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

2.1.2.Судалгаа арга зүйн байгууллагуудтай хамтран ажиллаж, сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулна.

2.1.3.Багш нарт мэргэжлээрээ бие дааж, тасралтгүй хөгжих боломжийг олгох, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулна.

2.1.4.Цахим технологийг ашиглан хүн бүр суралцах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.

2.1.5.“Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.6.Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлж, дэмжлэг үзүүлэн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх “Хүүхэд хөгжлийн ордон” барина.

2.1.7.Сургуулиудад “Хөдөлмөр амралтын зуслан” байгуулж, түүнийг түшиглэн сургууль, цэцэрлэгүүдэд аж ахуй эрхлэх боломжийг нь бүрдүүлнэ.

2.1.8.Сургалтын бүх байгууллагын ариун цэврийн байгууламжийг сайжруулна.

2.1.9.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын таатай орчинг бүрдүүлэх, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг стандартад нийцүүлэх ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ.

2.1.10.Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллежийг дэмжиж, орон нутгийн онцлог давуу талд түшиглэн, мэргэжлийн төрлийг нэмэгдүүлнэ.

2.2 Эрүүл мэнд

Зорилт: Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.2.1. Иргэн бүрт эрүүл мэндийн боловсролыг олгож, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах ажлыг тасралтгүй зохион байгуулна.

2.2.2. Өсвөр насныхны эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл аж төрөх арга барилд суралцуулна.

2.2.3. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах бэлэн байдал, нөөц бүрдүүлэлт, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд тулгуурлан цахим сүлжээг нэвтрүүлж, иргэдийн өдөр тутмын оношилгоо, эмчилгээ, сувилгаа, сэргээн засах үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай үзүүлнэ.

2.2.5. Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой болон үүдэн эмнэлэг, эмийн сан, сувилал, сувилахуйн төв, ариутгал халдваргүйтгэл, лабораториудын үйл ажиллагааг дэмжиж ард иргэдэд хүрч үйлчлэх боломжийг нь бүрдүүлнэ.

2.2.6. Мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтныг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулна.

2.2.7. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл хүүхэд-Эрүүл Ирээдүй” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.2.8. “Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн төв”-ийг байгуулна.

2.2.9. Мандал суманд хүүхдийн эмнэлэг байгуулна.

2.2.10. Эмч, эмнэлгийн ажилтнуудын тогтвор суурьшлыг хангаж, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ.

2.2.11. Эх нялхасын эндэгдлийг бууруулна.

2.3 Гэр бүл, хүүхэд, залуучууд

Зорилт: Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.

2.3.1. Гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.3.2. Гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх олон нийтийн оролцоог хангаж, төрийн бус байгууллагыг дэмжиж, түр хамгаалах байрны орчин нөхцөлийг сайжруулна.

2.3.3. Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

2.3.4. Залуу гэр бүлийн нийгэмд хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

2.3.5. Сэлэнгэ нутгийн хөгжилд залуучуудын оролцоог хангаж, хамтран ажиллана.

2.3.6. Өсвөр насныханд зориулсан хөгжил, хамгааллын хөтөлбөр боловсруулан төрийн бус байгууллагын оролцоог хангана.

2.3.7. Хүүхдийн эрхийг хамгаалах, өв тэгш хүмүүжүүлэх, хөгжүүлэх, амьдралын нөхцөлийг сайжруулахад зохистой арга хэмжээг авна.

2.3.8. Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх ажлыг бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.

2.3.9. Хорих ял эдэлж буй болон суллагдсан иргэд, залуучуудад хууль, эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нийгэмшүүлэх чиглэлээр сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулах, амьдрах орчин, нөхцөл, гэр бүлийн байдал, мэргэжлийн ур чадвар зэргийг судлан амьжиргааг дэмжих хөтөлбөрт хамруулна.

2.4 Шинжлэх ухаан, технологи, инноваци

Зорилт: Эдийн засаг, нийгмийн хөгжилд шинжлэх ухаан, технологи, инновацийг дэмжинэ.

2.4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр хүний нөөцийг үе шаттай бэлтгэж, чадавхжуулах бодлого хэрэгжүүлнэ.

2.4.2. Аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд салбарын эрдэмтэн, судлаачдын оролцоог хангана.

2.4.3. "Хөдөө аж ахуйн их сургууль"-ийн салбарыг байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.4.4. Орон нутагт оюуны өмчийг бүртгэн, хадгалж, хамгаалах ажлыг зохион байгуулна.

2.5 Хүнд ээлтэй амьдрах орчин

Зорилт: Эрүүл, аюулгүй баталгаат амьдрах орчныг бий болгоно.

2.5.1. Хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтад тавих хяналтыг сайжруулж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа мах, сүүний үйлдвэрлэлийн боловсруулалтыг нэмэгдүүлнэ.

2.5.2. Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, ээлтэй орчинг бүрдүүлнэ.

2.5.3. Орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.

2.5.4. Суурин газрын үерийн далан, борооны болон хөрсний ус зайлуулах суваг шуудууны аюулгүйн бүсийг тогтоож, хүнд ээлтэй орчинг бүрдүүлнэ.

2.5.5. Хүнсний сүлжээний бүртгэл, чанарын удирдлага, хяналт баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.

2.6 Хөдөлмөрийн зах зээл

Зорилт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, орлого олох боломжийг бүрдүүлнэ.

2.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй болон ажилгүй залуучуудыг аж ахуй эрхлэх болон ур чадвар олгох сургалтанд хамруулна.

2.6.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулж, мэдээллийн санг өргөжүүлнэ.

2.6.3. Ажил олгогчийн захиалгыг үндэслэн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулна.

2.6.4. Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангуулах, ажилтан, ажил олгогчийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.7 Монгол хүний удмын сан

Зорилт: Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.

2.7.1.Хүн бүр удмаа мэдэж, өрх бүрийг угийн бичгээ хөтлүүлэх ажлыг өрнүүлнэ.

2.7.2.Оюун ухааны хомсдол болон сэтгэл мэдрэлийн өвчнөөс урьдчилан эрт оношлох, сэргийлэх бодлого явуулах, хүн амын сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

2.7.3.Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхийг сайжруулна.

ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

3.1 Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл

Зорилт: Нийгмийн хамгааллын шинэчлэлд иргэн бүрээ хамруулна.

3.1.1.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.

3.1.2."Ковид-19" цар тахлын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг эн түрүүнд шийдвэрлэж, үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах нөхцөл боломжоор хангана.

3.1.3.Нийгмийн даатгалын цахимаар үзүүлэх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

3.1.4.Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд хүргэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.

3.1.5.Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслийг хэрэгжүүлнэ.

3.1.6.Ахмад настнуудад зориулсан үйлчилгээг өргөжүүлнэ.

3.2 Орлогод нийцсэн орон байр

Зорилт: Өрхийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах бодлого хэрэгжүүлнэ.

3.2.1.Орон сууц барих аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.2. "Амины орон сууц" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.3."Манай гэр-Миний гудамж" хөтөлбөрийн хүрээнд "Хашаандаа сайхан амьдарцгаая", "Сумандаа сайхан амьдарья" аяныг өрнүүлнэ.

3.3 Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес

Зорилт: Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

3.3.1.Залуучуудад бизнес эрхлэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлж, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.2.Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулна.

3.3.3.Малчид, хүнсний ногоо тариалагчдыг хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дэмжиж, гадаад дотоодын төсөл хөтөлбөрт хамруулна.

3.4 Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилт:*Ард иргэд, хүүхэд залуучуудаа бялдаржуулан чийрэгжүүлж, эрүүлжүүлэх зорилт хэрэгжүүлнэ.*

3.4.1.Нийтийн биеийн тамирыг иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.

3.4.2.Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

3.4.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон төрөлт тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулна.

3.4.4.Мэргэжлийн, багийн, өвлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ.

3.4.5.Бүх сумд, байгууллагыг орон тооны бус биеийн тамирын арга зүйчтэй болгоно.

3.4.6.Клуб холбоо, багш дасгалжуулагчдын ажлын үр дүнд суурилсан урамшууллын хөшүүрэг нэвтрүүлнэ.

3.4.7.Спортын төрлүүдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулна.

3.4.8.Иргэд, хүүхэд залуучуудад үйлчлэх спортын зориулалтын орчин нөхцөлийг сайжруулна.

3.5 Газрын харилцаа

Зорилт:*Газрын харилцаа, геодизи, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.*

3.5.1.Өрх бүрийг хаягжуулж, хаягийн мэдээллийн нэгдсэн систем үүсгэх ажлыг зохион байгуулна.

3.5.2.Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.

3.5.3.Зайнаас тандан судлах аргууд болон нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглан газар ашиглалт, нөхөн сэргээлтийн хяналтын механизмыг сайжруулна.

3.5.4.Газрын бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлнэ.

3.5.5.Барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.

3.5.6.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, газрын харилцааны нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

3.5.7.Сумдын хилийн цэсийн асуудлыг дээд шатны байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлэх

ДӨРӨВ. “ЭДИЙН ЗАСАГ”

Зорилго:Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой үялдуулан ил тод нээлттэй төлөвлөн хуваарилж, аймгийн эдийн засгийн үр ашгийг тогтвортой өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.

4.1 Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Зорилт:Эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлал, үйлвэрлэлийн салбарт түшиглэсэн эдийн засгийн бүс нутаг болно.

4.1.1.Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

4.1.2.Орон нутгийн бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, төрийн худалдан авалтыг дотоодын үйлдвэрлэлээс нийлүүлэх бодлого баримтална.

4.1.3.Аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн нэгдсэн тооллогыг явуулж, үйлдвэрлэлийн салбарын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, цаашдын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.1.4.Олон улсын авто зам, төмөр замыг түшиглэн тээвэр ложистикийн төв байгуулна.

4.1.5.Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлал, үйлвэрлэлийн салбарын татварын суурь баазыг нэмэгдүүлнэ.

4.1.6.Газар тариалан, төмс хүнсний ногоо эрхлэгч, жижиг дунд түвшиний иргэдийн орлогыг нэмэгдүүлэн, зах зээлийн хүрээг нэмэгдүүлнэ.

4.2.Ухаалаг санхүүгийн бодлого

Зорилт: Эдийн засгийн тогтвортой өсөлт өрх бүрдээ хүрсэн, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалын салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно.

4.2.1.Татварын бааз суурийг нэмэгдүүлэхийн тулд аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн нэгдсэн мэдээллийг нэгтгэх, салбар дундын харилцаа, уялдаа холбоог хангаж ажиллана.

4.2.2.Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлж төсөв санхүүгийн ил тод байдлыг хангана.

4.2.3.Алтанбулаг сумын хилийн боомтын орчинд валют арилжаа явуулж буй иргэдийг бүртгэлжүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлага хангасан үйлчилгээг бий болгоно.

4.2.4. Аймгийн төвд Монгол банкны салбарыг байгуулна.

4.3 Өрсөлдөх чадвартай Брэнд бүтээгдэхүүн

Зорилт: Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

4.3.1.Орон нутгийн онцлог, нөөцөд суурилсан чанар, стандартын шаардлага хангасан, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор “Сум бүрт нэг үйлдвэр-үйлчилгээ” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3.2.Орон нутгийн онцлогийг тусгасан гар урлал, бэлэг дурсгалын

бүтээлийн уралдаан зарлаж, иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, борлуулалтын сүлжээ цэгийг нийслэл болон төв зам дагуу бий болгоно

4.3.3.Худалдаа, үйлчилгээний газруудад биржийн арилжаа, цахим худалдааны шинэ төрөл, хэлбэрүүдийг нэвтрүүлж, үйлчилгээний соёл, ёс зүйг төлөвшүүлнэ.

4.3.4.Хил, гаалийн байгууллагуудтай хамтран гадаад худалдаанд цахим нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлж, худалдааг хөнгөвчлөх ажлыг зохион байгуулна.

4.3.5.Аймгийн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын болон хөрш орнуудын зах зээлд гаргах зорилгоор үзэсгэлэн худалдаа, экспо арга хэмжээг зохион байгуулж хэвшинэ.

4.3.6.Ахуйн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулан үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүдийг бий болгоно.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго: Чадварлаг, ухаалаг, хүртээмжтэй, нээлттэй засаглалын тогтолцоог бэхжүүлнэ.

5.1.Ухаалаг бүтэц

Зорилт: Нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг боловсронгуй болгоно.

5.1.1.Нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн шинжилгээг хийж, ажил үүргийн давхцалыг арилгах талаар саналыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлнэ.

5.1.2.Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх шууд утсыг төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллуулж, иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэнэ.

5.1.3.ОХУ, БНХАУ болон хамтын ажиллагаатай бусад улс, муж, хотуудтай харилцаагаа бэхжүүлж, шинэ түншлэлийг нэмэгдүүлнэ.

5.2 Цахим засаглал

Зорилт: Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.2.1.Ерөө сумын Бугант тосгоны төр төсвийн байгууллагуудыг шилэн кабельд холбож, хүн амыг өндөр хурдын интернетийн үйлчилгээгээр хангана.

5.2.2.Аймаг, сумын хэмжээнд “E-Mongolia” үйлчилгээг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг операторийн горимоор үзүүлэх ажлыг тогтмолжуулна.

5.2.3.Төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн байгууллагын ажил үйлчилгээг цаасан суурьт болон цахим сэтгүүлээр нийтэд сурталчилна.

5.2.4.Иргэд олон нийтэд мэдээллийг ил тод, хурдан шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн, аймаг, орон нутгаас тодорсон алдартан гавьяатан, шинийг санаачлагч, баялаг бүтээгчдийг алдаршуулна.

5.2.5.Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулж, улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

5.3 Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба

Зорилт: Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.

5.3.1.Төрийн байгууллагуудад чадахуйн зарчмыг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

5.3.2."Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах", "Суралцагч байгууллага-төрийн албаны манлайлал" хөтөлбөрийг төрийн байгууллагуудад хэрэгжүүлнэ.

5.3.3.Аймгийн хэмжээнд "Чанарын чуулган" зохион байгуулж, "Чанарыг эрхэмлэгч байгууллага" шагналыг бий болгон үйлчилгээний чанарын стандартыг орон нутагт хэрэгжүүлнэ.

5.4. Ухаалаг засаглал

Зорилт: Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх мэдээллийн дэд бүтцийг хэрэглээнд нэвтрүүлнэ.

5.4.1.Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Сэлэнгэ хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан"-г нэвтрүүлнэ.

5.4.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт төлөвлөлтийн, явцын, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, нутгийн захиргааны байгууллагуудын менежментийг сайжруулна.

5.4.3.Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн үр нөлөөнд дотоод аудит хийх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

5.4.4.Нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах ажлыг эхлүүлнэ.

5.4.5.Орон нутгийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүдийн мэдлэг ур, чадварыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

5.4.6.Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох, багийн чадавхийг бэхжүүлэх, баг, иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэн тэдгээрийн эрэлт хүсэлтийг шуурхай шийдвэрлэнэ.

5.5 Хүний эрхийг дээдэлсэн нийгэм

Зорилт: Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах бодлого хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.

5.5.1.Аж ахуйн нэгж, хувийн хэвшил дэх хүний эрхийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлнэ.

5.5.2.Хууль тогтоомж сурталчлах зөвлөгөө өгөх "Эрх зүйн хөтөч"-ийг багуудад ажиллуулах асуудлыг судлан, хууль, эрх зүйн албан бус сургалт зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр зохион байгуулж, сургалтын үйл ажиллагаа нь зорилтот бүлгүүдэд хүрсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.5.3. "Хууль зүйн туслалцааны төв"-ийг бүсийн төвүүдэд байгуулна.

5.6 Авлигагүй засаглал

Зорилт: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.

5.6.1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулна.

5.6.2. Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог төлөвшүүлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.

ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ

Зорилго: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулна.

6.1 Байгалийн баялгийн үр өгөөж

Зорилт: Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах бодлого хэрэгжүүлнэ.

6.1.1. Ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.

6.1.2. Уул уурхайн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг нэмэгдүүлнэ.

6.1.3. Хариуцлагатай тогтвортой уул уурхайг дэмжиж, хамтран ажиллаж, "Сэлэнгэ баялаг сан" байгуулж нийгмийн хариуцлага, үр дүнг тооцож байгалийн баялгийн үр шимийг нийгмийн салбарт зориулна.

6.1.4. Экологийн болон эдийн засгийн ач холбогдолтой газар нутгийн судалгааг хийж, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.

6.2 Үнэт баялаг ус

Зорилт: Усны нөөцийг хамгаалж, хуримтлал бий болгон, хомсдол, бохирдлоос сэргийлнэ.

6.2.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.

6.2.2. Хур борооны усыг ашиглан хөв цөөрөм байгуулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ашиглана.

6.2.3. Аймгийн хэмжээнд гүний усны нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэнэ.

6.2.4. Хараа, Ерөө голын загасны судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

6.3 Хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт: Байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.

6.3.1. Ойгоос мод бэлтгэх хуваарь, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.

6.3.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тогтвортой ногоон сум, ногосн барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг төлөвшүүлнэ.

6.3.3.Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглах үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжин, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

6.3.4.Аймгийн хэмжээнд агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.

6.3.5.Аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалттай байгууламж барьж, сөрөг нөлөөг бууруулна.

6.3.6.Аймгийн хэмжээнд нэн ховор, ховор амьтанд зориулан биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

6.3.7.Байгууллага бүрт “Ногоон оффис” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Зорилго: Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, орон нутгийн аюулгүй байдлыг хангана.

7.1 Зэвсэгт хүчин

Зорилт:Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг ард иргэдэд сурталчилсанаар иргэдийн иргэний цэргийн үүргээ биелүүлэх мэдлэг, хандлагыг дээшлүүлнэ.

7.1.1.Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлах сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.

7.1.2.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

7.1.3.Дайчилгааны бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтуудыг зохион байгуулж, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоог нэмж, чанарыг нь сайжруулна.

7.1.4.Цэргийн дүйцүүлэх албыг сурталчлах, алба хааж байгаа иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалт, бусад арга хэмжээнд татан оролцуулна.

7.1.5.“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

7.2. Дархан хил

Зорилт:Улсын хил хамгаалалтад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хил хамгаалах албаны бэлэн байдлыг дээшлүүлнэ.

7.2.1.Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд ахиц гаргаж, хил хамгаалах албыг бэхжүүлэн, хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.

7.2.2. Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.

7.2.3.Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлж, сайн дураар хил хамгаалалтад оролцогч иргэдийн санал, санаачлагыг дэмжин ажиллана.

7.3. Хүн нийгмийн амар, тайван байдал

Зорилт: Улсын батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн амар, тайван аюулгүй байдлыг хангана.

7.3.1.Гэмт хэрэг, зөрчил болон болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, ажилд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

7.3.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хил болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулна.

7.3.3.Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, нийт гэмт хэрэгт эзлэх хувийг бууруулна.

7.3.4.Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, таслан зогсооход төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, өрх, гэр бүлийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.

7.4 Хууль сахиулах салбарын хөгжил

Зорилт: Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, зарим төрлийн үйлчилгээг цахимжуулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргана.

7.4.1.Оршин суугаа нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.4.2.Гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

7.4.3.“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнд хүргэнэ.

7.4.4.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг таслан зогсооно.

7.4.5.Хууль хяналтын байгууллагуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан, хүний нөөцийг чадавхижуулж, салбар дундын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргана.

7.4.6.Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулна.

7.4.7.Улсын бүртгэлийн хэлтсийг архив, үйлчилгээний байртай болгох асуудлыг судалж, мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

7.4.8.Иргэний тоон гарын үсэгт суурилсан иргэний үнэмлэхийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлнэ.

7.4.9.Бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.

7.4.10.Төрийн Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын стандартын байртай болно.

7.4.11.Төрийн Архивын баримтыг цахимжуулна.

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго: Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, орон нутгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулна.

8.1 Дэд бүтэц

Зорилт: Хот суурин газрын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.

8.1.1. Сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

8.1.2. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламжийг дахин төлөвлөлтөд оруулна.

8.1.3. Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

8.1.4. Мандал суманд дулааны станц барьж ашиглалтад оруулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

8.1.5. Эрчим хүчний нөөцийг ашиглан эх үүсвэр барих, шугам сүлжээ, ачаалал ихтэй дэд станцуудыг өргөтгөх, шинэчлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

8.1.6. Олон улсын болон улс, орон нутгийн авто замын сүлжээнд засвар, шинэчлэлтийн ажлыг хийнэ.

8.1.7. Насжилт удаашралтай гүүрэн байгууламж, бетон гүүрэнд их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

8.1.8. Зарим сумдад инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологи нэвтрүүлж, дулааны тоолуурыг бүрэн суурилуулна.

8.1.9. Аймгийн төвд орчин үеийн шаардлагад нийцсэн нийтийн тээврийн зогсоол бий болгоно.

8.2 Аялал жуулчлал

Зорилт: Байгалийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт байгаль, түүх, соёлын өвийг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлж дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

8.2.1. Байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв, соёлыг хадгалан нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг /НИТАЖ/ бүсчилэн хөгжүүлнэ.

8.2.2. Аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэгүүдийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулна.

8.2.3. "Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

8.2.4. Аймгийн аялал жуулчлалын маршрут, амралтын газруудын байршлыг харуулсан аппликейшныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж нэвтрүүлнэ.

8.3 Тогтвортой хөдөө аж ахуй

Зорилт: Цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицсон цогц, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

8.3.1. "АТАР IV" аяныг өрнүүлэн, тариалангийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, Сэлэнгэ аймгийн газар тариалангийн бодлогыг боловсруулна.

8.3.2. Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас, хашаажуулах төслийг хэрэгжүүлэн эрдэм шинжилгээний байгууллагууд, төр хувийн хэвшлийн оролцоотойгоор ирээдүйтэй болон нутагшсан

үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.

8.3.3.Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин, хүлэмжийн болон зоорийн аж ахуйг хөгжүүлж, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ.

8.3.4.Бордооны хангамжийг нэмэгдүүлж, тариалах талбайн 80 хувьд бордоотой тариалалт эрхэлж га-аас авах ургацын хэмжээг тогтворжуулна.

8.3.5.Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.

8.3.6.“Монгол мал-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулна.

8.3.7. Мал эмнэлэгийн ариутгал, халдваргүйтгэл, хяналт шалгалтын нэгдсэн цэгийг Тахилт, Хөшөөтийн даваанд байгуулна.

8.3.8.Мал, амьтны гарал үүслийн гэрчилгээ, баталгаажуулалтын нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, гадаад, дотоод худалдааны чөлөөт байдлыг хангана

8.3.9.Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг хэрэгжүүлэн тариалах талбайн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж боловсруулах цехтэй болно.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР